

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

БАРИЛГА ЗАХИАЛАГЧ, ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-
ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Хаяг: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.13 № 01/240
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ
ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ДАШДЭМБЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ нь барилгын зураг төсөв, техникийн норм, дүрмийг дагаж мөрдүүлэх, зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилга бариулах, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх" гэсэн зорилгыг тодорхойлон ажиллажээ.

Аудитын гол асуудал

Нийт орлогын гүйцэтгэлийг 664,075.8 мянган төгрөгөөр төлөвснөөс 433,796.0 мянган төгрөг буюу 65,3 хувиар биелүүлж, 34,7%-иар тасарсан нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаас орох захиалагчийн хяналтын орлого бүрдээгүйгээс шалтгаалжээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд үйл ажиллагааны ашиг үр дүнг 84,203.8 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 51.1 мянган төгрөг буюу 93.9%-иар тасарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,906,811.88	88,730,344.14
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	57,743,555.66	5,645,549.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	57,743,555.66	5,645,549.19
3121	Төгрөг	57,743,555.66	5,645,549.19
31213	Арилжааны банк дахь харилцах	57,743,555.66	5,645,549.19
33	АВЛАГА	163,916.22	78,619,254.95
33401	Дансны авлага /ТӨҮГ/	-	78,609,257.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	163,916.22	9,997.95
35	БАРАА МАТЕРИАЛ	3,999,340.00	4,465,540.00
354	Хангамжийн материал	3,999,340.00	4,465,540.00
35410	Бичиг хэргийн материал	1,111,540.00	2,019,040.00
35420	Аж ахуйн материал	2,037,800.00	2,426,500.00
35440	Түлш, шатах тослох материал	850,000.00	20,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,239,270,253.34	4,339,047,445.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,239,270,253.34	4,339,047,445.02
392	Биет хөрөнгө	20,267,586.68	120,367,445.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	98,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,346,800.00	41,846,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,066,131.65)	(29,498,244.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,964,500.00	22,386,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,977,581.67)	(12,368,010.00)
393	Биет бус хөрөнгө	4,219,002,666.66	4,218,680,000.00
39301	Програм хангамж	3,660,000.00	3,660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,117,333.34)	(3,440,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,218,460,000.00	4,218,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,301,177,065.22	4,427,777,789.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,060,883.47	29,615,590.08
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,060,883.47	29,615,590.08
413	Өглөг	1,060,883.47	29,615,590.08
4136	Бусад өглөг	1,060,883.47	29,615,590.08
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	1,060,883.47	29,615,590.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,300,116,182.75	4,398,162,200.07
51	Засгийн газрын хувь оролцоо	4,300,116,182.75	4,398,162,200.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,000,000.00	1,000,000.00
51101	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,299,116,182.75	4,397,162,200.07
51210	Өмнөх үеийн үр дүн	4,299,116,182.75	4,299,116,182.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	98,046,017.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,301,177,066.22	4,427,777,790.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	374,254,079.00	609,095,276.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	374,254,079.00	609,095,276.00
120	Нийтлэг татварын бус орлого	374,254,079.00	609,095,276.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	374,254,079.00	511,095,276.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	374,254,079.00	511,095,276.00
120009	Бусад орлого	-	98,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	358,499,287.97	509,757,145.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,499,287.97	509,757,145.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,499,287.97	509,757,145.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,880,480.00	385,036,319.00
210101	Үндсэн цалин	246,880,480.00	385,036,319.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,860,058.97	48,129,541.12
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	30,860,058.97	48,129,541.12
2104	Хангамж, бараа материалын зардал	19,546,190.00	13,728,080.00
210401	Бичиг хэрэг	3,518,590.00	187,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	941,820.00	10,230.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,205,780.00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	13,880,000.00	13,530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,310,700.00	-
210604	Урсгал засвар	2,310,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	15,972,000.00	9,006,000.00
210702	Дотоод албан томилолт	15,972,000.00	9,006,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,292,344.00	14,580,345.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00	288,000.00
210807	Газрын төлбөр	14,292,344.00	-
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	3,600,000.00	14,292,345.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,637,515.00	39,276,860.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,445,820.00	30,867,652.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,100,000.00	1,264,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,091,695.00	7,145,208.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,754,791.03	99,338,130.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,754,791.03	99,338,130.36

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	00.00	4,284,471,470.82		4,285,471,470.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00	0.00	4,284,471,470.82	0.00	4,285,471,470.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			13,644,711.93		13,644,711.93
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0.00	4,298,116,182.75	0.00	4,299,116,182.75
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0.00	4,298,116,182.75	0.00	4,299,116,182.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00	0.00	4,298,116,182.75	0.00	4,299,116,182.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	1,000,000.00	00.00	1,000,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	98,046,017.32	00.00	98,046,017.32
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0.00	4,397,162,200.07	0.00	4,398,162,200.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	374,254,079.00	433,796,019.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	374,254,079.00	433,796,019.00
120	Нийтлэг татварын бус орлого	374,254,079.00	433,796,019.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	374,254,079.00	433,796,019.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	350,509,653.65	476,971,625.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,509,653.65	476,971,625.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,509,653.65	476,971,625.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,470,306.00	318,655,427.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	214,470,306.00	318,655,427.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,251,311.97	92,418,715.07
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	59,251,311.97	92,418,715.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,990,530.00	1,764,730.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	1,990,530.00	1,764,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,583,540.00	17,002,570.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	15,009,000.00	14,700,400.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	4,574,540.00	2,302,170.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,213,965.68	47,130,183.40
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	20,980,921.68	40,149,553.40
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	34,233,044.00	6,980,630.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,744,425.35	(43,175,606.47)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,799,900.00	8,922,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,799,900.00	8,922,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,799,900.00	8,922,400.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	2,799,900.00	8,922,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,799,900.00)	(8,922,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,944,525.35	(52,098,006.47)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,799,030.31	57,743,555.66
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,743,555.66	5,645,549.19

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны гүйцэтгэл	2025 оны төсвийн төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ 2025.12.31-ны байдлаар	Зөрүү	Хувь
Орлого	374,254,079.00	664,075,803.00	433,796,019.00	230,279,784.00	65.3
Нийт орлого	374,254,079.00	664,075,803.00	433,796,019.00	230,279,784.00	65.3
I. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН /урсгал зардал+ХО зардал/	353,309,552.79	579,872,012.97	485,894,025.47	93,977,987.50	83.8
II. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	353,309,552.79	579,872,012.97	485,894,025.47	93,977,987.50	83.8
Бараа үйлчилгээний зардал	353,309,552.79	579,872,012.97	485,894,025.47	93,977,987.50	83.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,070,481.88	428,939,836.42	378,368,209.35	50,571,627.07	88.2
Үндсэн цалин	197,698,306.00	428,939,836.42	308,057,909.99	120,881,926.42	71.8
ХХАОАТ	20,980,921.68	35,972,235.69	24,970,239.62	11,001,996.07	69.4
НДШ	28,391,254.20	49,328,081.19	44,279,176.26	5,048,904.93	89.8
Гэрээт цалин	2,640,000.00	84,203,790.03	1,060,883.48	83,142,906.55	1.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,860,058.91	53,617,479.55	48,129,541.12	5,487,938.43	89.8
Тэтгэвэрийн даатгал	20,984,840.06	36,459,886.10	32,728,087.96	3,731,798.13	89.8
Тэтгэмжийн даатгал	2,468,804.71	4,289,398.36	3,850,363.29	439,035.07	89.8
ҮОМШ өвчний даатгал	1,975,043.77	3,431,518.69	3,080,290.63	351,228.06	89.8
Ажилгүйдлийн даатгал	493,760.94	857,879.67	770,072.66	87,807.01	89.8
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	4,937,609.43	8,578,796.73	7,700,726.58	878,070.15	89.8
ААНОАТатвар					
Байгууллагын тогтмол зардал	186,000.00	240,000.00	240,000.00	-	100.0
Цэвэр, бохир ус	186,000.00	240,000.00	240,000.00	-	100.0
Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	24,809,600.00	33,055,576.00	18,818,230.00	14,237,346.00	56.9
Тээвэр (шатахуун)	14,000,000.00	19,639,776.00	13,530,000.00	6,109,776.00	68.9
Шуудан, холбоо	1,615,210.00	1,954,800.00	1,301,960.00	652,840.00	66.6
Бичиг хэрэг	3,984,390.00	3,986,000.00	3,646,270.00	339,730.00	91.5
Ном, хэвлэл авах	-	325,000.00	-	325,000.00	0.0
Эрүүл мэнд, Тэтгэмж	5,210,000.00	7,150,000.00	-	7,150,000.00	0.0
Эд хогшлын зардал	2,799,900.00	16,000,000.00	8,922,400.00	7,077,600.00	55.8
Эд хогшил худалдан авах	2,799,900.00	16,000,000.00	8,922,400.00	7,077,600.00	55.8
Томилолт зочны зардал	19,072,000.00	23,270,000.00	11,170,000.00	12,100,000.00	48.0
Дотоод албан томилолт	15,972,000.00	19,060,000.00	9,006,000.00	10,054,000.00	47.3
Хичээл, сургалт, семинар, хурал, зочны зардал	3,100,000.00	4,210,000.00	2,164,000.00	2,046,000.00	51.4
Бараа үйлчилгээний бусад зардал	25,871,512.00	26,119,550.00	20,245,645.00	5,873,905.00	77.5
Техникийн нөхцөл, магадлал	5,968,768.00	4,389,200.00	2,363,000.00	2,026,200.00	53.8
Аудитын зэрэглэл тогтоох үйлч.хөлс	1,209,600.00	1,600,000.00	1,209,600.00	390,400.00	75.6
Газрын төлбөр	14,435,344.00	15,780,350.00	14,292,345.00	1,488,005.00	90.6
Тээврийн хэрэгслийн зардал	1,998,300.00	2,050,000.00	2,035,400.00	14,600.00	99.3
Зар сурталчилгааны зардал	2,200,000.00	2,200,000.00	288,000.00	1,912,000.00	13.1
Дансны шимтгэл	59,500.00	100,000.00	57,300.00	42,700.00	57.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, ҮР ДҮН	13,644,711.93	84,203,790.03	46,017.33	84,157,772.70	0.0546
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1		
АЖИЛЛАГСАД БҮГД	8	13	12		
Удирдах ажилтан	1	1	1		
Гүйцэтгэх ажилтан	5	10	10		
Үйлчлэх ажилтан	2	2	1		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 4,218,460.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Залруулсан алдаа:

Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийн өмнөх оны үлдэгдлийг 4,218,460.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 166,077.3 мянган төгрөгийн зөрчлөөс 680.0 мянган төгрөгийн материаллаг, 165,397.3 мянган төгрөгийн материаллаг бус зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 7,288.4 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 166,077.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 680.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичиж, 5 зөвлөмж хүргүүллээ.

Залруулаагүй алдаа:

5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллага уралдаан тэмцээнд оролцсон албан томилолтын зардалд 680.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд БЗОСК-ийн даргын 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн А/02 тушаалаар хүүхдийн баярын бэлгэд 900.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгал худалдан авахгүй байх.

2. Авлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд 2 байгууллагаас захиалагчийн хяналтын зардлын авлага 77,299.3 мянган төгрөг, 2 ажилтанд илүү олгосон цалингийн авлага 1,310.0 мянган төгрөг, НДШ-н авлага 9.9 мянган төгрөг нийт 78,619.2 мянган төгрөгийн авлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулж, цаашид шинээр авлага үүсгэхгүй ажиллах.

3. Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд ААНОАТ 5.1 мянган төгрөг, НӨАТ-д 21,889.0 мянган төгрөг, ХХОАТ-д 7,721.5 мянган төгрөгийн нийт 28,554.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 29,615.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өр, төлбөрийг барагдуулж, цаашид шинээр өр төлбөр үүсгэхгүй ажиллах

4. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын худалдан авалтыг мөнгөн гүйлгээний журнал, зардлын дэлгэрэнгүй журналаас НӨАТ-ийг тулган шалгахад 56,267.6 мянган төгрөгийн 13 ААНБ-ын худалдан авалтыг е баримтад дутуу зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг хангаагүй болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын баримтыг тулгаж, зөрүү гаргахгүй байх.

5. Шилэн данстай асуудал

Тус байгууллагын шилэн дансанд аудит хийхэд хугацаа хоцролтын хэрэгжилт 85,6%, хугацаа хоцроосон мэдээлэл 21 байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Биет бус хөрөнгө өмнөх оны үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан	1	4,218,460.0	1	4,218,460.0			1	4,218,460.0				
Дүн	1	4,218,460.0	1	4,218,460.0			1	4,218,460.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
уралдаан тэмцээний оролцсон албан томилолтын зардалд 680.0 мянган төгрөг зарцуулсан	1	680.0	1	680.0				
тайлант онд 78,619.2 мянган төгрөгийн авлагатай байна	1	78,619.3					1	78,619.3
тайлант онд 29,615.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна	1	29,610.5					1	29,610.5
Тус байгууллага тайлант онд 13 ААНБ-ын худалдан авалтыг е баримтад дутуу зөрүүтэй тайлагнасан.	1	56,267.6					1	56,267.6
хүүхдийн баярын бэлгэд 900.0 мянган төгрөг зарцуулсан	1	900.0					1	900.0
Дүн	1	166,077.3	1	680.0			4	165,397.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансанд аудит хийхэд шилэн дансанд аудит хийхэд хугацаа хоцролтын хэрэгжилт 85,6%, хугацаа хоцроосон мэдээлэл 21 байна	1	0					1	0
Дүн	1	0					1	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn